

Living the Lotus

Buddhism in Everyday Life

New Year's Issue

Түүх соёлоо дээдлэн урагшлах

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

**Байгууллагын 100 жилийн ойг зорин
бүх гишүүд нэгэн сэтгэлээр хүүхэд
залуусын хүмүүжил боловсролын төлөө
зүтгэцгээе.**

Та бүхэнд шинэ оны мэнд дэвшүүлэе.

Энэ жил ч гэсэн цоо шинэ сэтгэлээр,
бурхны зам мөрөөр өөдрөг эрч хүчтэй
алхацгаая.

Шинэ жил гэдгийн шинэ буюу “新” /
шин/ гэдэг ханз нь “辛” /шин/ буюу зовлон
бэрхшээл, хичээл зүтгэл, “木” /ки/ буюу
мод, “斤” /кин/ буюу сүх гэсэн утгатай
гурван ханз үсэгнээс бүтдэг. Өөрөөр
хэлбэл модыг хайрлан ургуулж, түүнийгээ
хичээнгүйлэн өнгөлж зүлгэн шинэчлэн
сэргээж ашиглах гэсэн утга шингэсэн
байдаг.

Хүний амьдрал дээр аваад үзэх юм бол
өмнөх үеийнхнийхээ үлдээсэн түүх, ёс
заншлаас суралцаж, хүндэтгэн дээдлэхийн
зэрэгцээ орчин үетэйгээ хөл нийлүүлэн
бүтээлч санаачлагатай байж, шинийг хийж
бүтээхийн төлөө зүтгэх гэсэн үг болно.

Энэ жил “新” /шин/ буюу “шинэ”
хэмээх ханзны гүн гүнзгий утгыг

эрэгцүүлэн бодож, хамтдаа урагш
алхацгаая хэмээн уриалж байна.

Ингээд би “2026 оны зорилт”-ыг ийнхүү
тодорхойллоо.

Өнгөрсөн жилийг Японд Шёовагийн он
тооллын 100 жил гэж хэлж ярьж байсан.
Шёовагийн 13-р он буюу 1938 онд
байгуулагдсан манай байгууллага 12
жилийн дараа 2038 онд 100 жилийн
ойтойгоо золгоно.

Бид үүнийг сайтар санаж, энэ жил ч
гэсэн сүсэг бишрэл бүхий амьдралаараа



дамжуулан хүүхэд залууст хүний зам мөрийг ухааруулж, хүнлэг мөн чанарыг суулгаж, өрх гэрээ товхиууж, улс орныхоо ёс заншлыг уламжлан авч, сайхан улс орныг бүтээхийн төлөө хамтдаа өөдрөг, эрч хүчтэй хичээн зүтгэцгээе.

Би 2018 онд РКК байгууллагын 80 жилийн ойгоор ирж буй 100 жилийн ойн бидний эрхэм зорилго бол “хүн бэлдэх” гэсэн үндсэн асуудалд хамаг хүчээ дайчлах гэж хэлж байсан.

Ирээдүйг бүтээх хүүхэд залууст хүний зам мөр (бодисатвагийн зам мөр)-ийг ухааруулж, хүний мөн чанарыг суулгах нь манай байгууллага төдийгүй нийгэм нийтийн хувьд ч нэн чухал асуудал билээ.

РКК байгууллага “Өрх гэрээ товхиуулах”-ыг үндсэн зорилтоо болгосон нь гэр бүл бол хүнийг өсгөн хүмүүжүүлэх гол газар учраас тэр юм.

Эцэг эх нь бурхан тахилаа дээдлэн амьдарч, үргэлж гэгээлэг, эелдэг, зөөлөн дулаан үг, үйлдэл хийхэд анхаарах юм бол хүүхдийн хүмүүжил төлөвшилд мэдэгдэхүйц өөрчлөлт гарна.

Тэр дундаа нэн чухал зүйл бол бага балчир насны гэр бүлийн хүмүүжил болно.

Японы уламжлалт баяр ёслол болох “Шичигосан” нь сургуулийн боловсролын өмнөх 7, 5, 3 насанд гэр бүлийн хүмүүжил хамгаас чухал болохыг илэрхийлдэг.

Түүнчлэн тархи хамгийн саруул, хурц байдаг нас бол 10-аас 13, 14 нас, нүдний хараа хамгийн сайн байдаг нас бол 9-10 нас гэх ба “тэр хүүхэд цоолох шахам хурц нүдтэй” гэсэн хэлц хүртэл бий. Төсөөлөх, ургуулан бодох, ой санамж бол 11, 12 насанд хамгийн хүчтэй байх ба 15, 16 наснаас хүүхэд өөртөө итгэлтэй бие хүн болж төлөвшдөг.

Хүүхдийн ийм чухал насанд гэр бүлийн хүмүүжилд анхаарахгүй, бүхнийг сургуульд найдаад орхичих юм бол хүүхэд залуусын хүмүүжил төлөвшил талаар болно гэдгийг сайтар санаж явах хэрэгтэй. Нийгэмд гарч буй хүүхэд залуусын асуудал ч гэсэн эцсийн эцэст эцэг эхчүүдийн ухамсар, үүрэг хариуцлага, үйл хөдлөлтэй нягт холбоотой гэж хэлэхэд хэлсдэхгүй.

“Улс төр ч тэр, эдийн засаг ч тэр хүүхэд багачуудын хүмүүжил боловсролын төлөө оршдог” гэж нэг хүн хэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл томчууд нь хүүхэд залуусыг зөв хүмүүжүүлэхэд шаардлагатай нийгмийг байгуулах үүрэгтэй гэсэн үг.

Мөн залуу үе нь улс орноороо бахархаж амьдрах маш чухал. Улс орноо хайрлаж,



РКК нийгэмлэгийн анхны
төвийн бурхан тахилын өмнө

Анхны төв 1948 оны 12-р сарын 28-нд баригдаж, 1964 онд Их ариун ордон баригдах хүртэл удирдах төв болж байсан юм. 1994 онд Их ариун ордны 30 жилийн ойгоор нэрийг нь өөрчилсөн хэдий ч, «гишүүд хуучин төв» хэмээн дотночилон дуудаж, сэтгэлдээ дурсан санааар байдаг билээ. 2011 оны Зүүн бүсийн газар хөдлөлтөөр их засвар хийх үед дээр үеийн уур амьсгалыг гишүүдэд мэдрүүлэх зорилгоор 1963 онд Их ариун ордонд залсан Нивано Үүсгэн байгуулагчийн зурсан “Хот мандал” зургийн хуулбарыг гол шүтээнээ залсан түүхтэй.

дээдэлдэг болсноор хүүхэд залуусын хүмүүжил дагаад сайжирдаг учраас тэр.

Ялангуяа Япон бол арвин түүх, ёс заншилтай орны нэг. Дэлхийд байхгүй өөрийн онцлог бүхий эзэн хаан, хааны ордонтой, улс гүрэн байгуулагдсан цагаас өнөөг хүртэл ард иргэд нь эв нэгдлийг эрхэмлэж оюун санааны баялаг түүх соёлыг бүтээсэн.

Японыг дээр үед “Ямато” (агуу эв нэгдэл) гэдэг байсан ба агуу энх тайван, агуу зохицол гэсэн үзэл санааг ямагт эрхэмлэн улсынхаа зорилго болгосоор ирсэн.

Хунтайж Шоотокү (574–622) 17 зүйлт үндсэн хуулиндаа “Бидний үнэт зүйл бол эв нэгдэл” гэж заасан.

Ийнхүү энх тайван, эв нэгдлийг эрхэмлэх Япон улсын ёс заншлыг уламжлан авч, бахдам сайхан улсыг бүтээхийн төлөө хичээх нь “хүн бэлдэх” гэдэг талаас нь аваад үзсэн ч нэн чухал зүйл юм.

12 жилийн дараах байгууллагын 100 жилийн ойн зорилт болгож бүх гишүүд нэгэн сэтгэлээр өөр өөрсдийн байр сууринаас хүүхэд залуусыг өсгөн хүмүүжүүлэхэд хүчээ зориулахыг хүсэж байна.

Талархсан сэтгэлээр, амьдрах эрч хүч дүүрэн бодисатвагийн зам мөрөөр алхах. Энэ бол Шагжамүни бурхны туйлын хүсэл.

Би өнгөрсөн жил хий насаар 88 хүрч, тэмдэглэлт жил тохиосон тул 3 сарын 20-ны төрсөн өдрөөс минь авхуулаад Их ариун ордонд сар бүр баярын арга хэмжээ зохион байгуулсан. Арга хэмжээгээр гишүүд “Косей кай нийгэмлэгийн гишүүн болсондоо үнэхээр баярлаж явдаг” гэж хэлэхийг сонсох тоолонд миний сэтгэл үнэхээр баяртай байсан. Тус нийгэмлэгийн гишүүний хувиар хамтдаа алхам алхмаар урагш ахисаар иржээ гэж бодогдохын сацуу өнцөг булан бүрээс хамаатан садан маань цугларан ирж төрсөн өдрийг минь тэмлэглэж өгч байгаа мэт санагдан үнэхээр

их сэтгэл хөдөлсөн. Та бүхэндээ маш их баярлалаа.

Ямар ч хүн өтөлж хөгшрөх нь байгалийн хууль атал ихэнх хүн хөгшрөх дургүй, хөгшрөхөөс зугтах хандлагатай байдаг. Хөгшрөх дургүй байгаа цагт хүний хувьд боловсорч гүйцээгүй байна гэсэн үг.

Хөгшрөх гэдэг зөвхөн нас нэмэхийг хэлж буй хэрэг биш. Угтаа олон арвин туршлага хуримтлуулж, бодол санаа гүнзгийрч, хүний хувьд өсөж хөгжих хичээл зүтгэлийн үе шат тул маш утга учиртай, бахархалтай зүйл гэж хүлээж авах нь зүйтэй.

Мэдээж хэрэг ямар ч зүйлд “ингээд төгс боллоо” гэсэн юм байдаггүй. Тийм ч учраас хүн үргэлж сурч мэдэж, хүний хувьд өсөж хөгжихийн төлөө хичээдэг. Миязава Кэнжи гуай “Төгс бус гэдэг өөрөө төгс” гэж хэлсэн. Энэ нь бүхнийг ойлгочихлоо гэж хямдхан бодолгүй амьралынхаа турш зам мөрийг эрэлхийлж явах нь өөрөө төгс амьдрал гэдгийг хэлсэн болов уу.

Бодоод үзвэл би ч гэсэн залуу байхдаа Косей кай нийгэмлэгийн сүсэг бишрэлийг эсэргүүцдэг байсан. Гэвч туршлага хуримтлуулж, сурч мэдэх явцад Шагжамүни бурхны бидэнд дамжуулахыг хүссэн үзэл санааг ойлгосон юм. Нас өндөр болсноос хойш бол бурхны сургаалыг бие сэтгэлээрээ мэдэрч хүлээж авдаг болсон.



“Дармапада” сударт гардаг дараах үгийг та бүхэн мэдэх байх.

“Хүний амь насыг олоход бэрх. Хэзээ нэгэн цагт үхэх амьдралд яг одоо амьд яваа нь юутай сайхан хэрэг вэ. Амь насыг оллоо гэхэд зөв сургаалтай учран золгоно гэдэг ховор. Хамаг бурхан орших ертөнцөд хүний амийг олно гэдэг ховор нандин учрал буй за.”

Энэ богинохон үгэнд Шагжамүни бурхны сургаал тэр чигээрээ оршдог гэж би боддог.

Бидний амь нас ямар гайхамшигтай, ариун нандин, талархмаар зүйл болох. Бурхны номтой учрах ямар ховор нандин учрал болох. Үүнийг ухаарах нь амьдралын утга учрыг ойлгох хамгийн чухал алхам болно.

Үглэж гомдоллон амьдрах бус хүртсэн амь насандаа талархаж, сэтгэл өөдрөг амьдрах. Бурхны номд суралцаж, сүсэг бишрэл бүхий амьдралаар амьдрах гэдэг товчхондоо үүнийг хэлэх болов уу.

Амьдралд олон янзын зовлон бэрхшээл тулгарах нь дамжиггүй. Гэсэн хэдий ч яг одоо энэ хором мөчид ямар олон хүний ачаар тусаар амьдарч байгаагаа олж харах юм бол ухарч няцалгүй өөдрөг амьдаръя гэсэн сэтгэл төрнө. Өнөөг хүртэл тааламжгүй санагдаж байсан үйл явдлын талархалтай талыг нь олж хардаг болно.

Тэр байтугай бид бүхэн бурханлаг чанартай, туйлын үнэн буюу бурхны Номыг ухаарч ойлгох, асуудлыг шийдвэрлэх чадвартай гэж сургадаг.

Тиймээс “би бол сул дорой”, “би чадахгүй” гэж бодолгүй Шагжамүни бурхны сургаалыг байгаагаар нь хүлээн авч, хэрэгжүүлэх нь аз жаргалтай амьдрах эхний алхам болно.

Би одоо хөл гараа хөдөлгөж, амьсгалж, ярьж, идэж ууж чадаж байна. Амьдралд зайлшгүй хэрэгтэй агаар, ус бол хүний бүтээсэн зүйл биш байгалийн хишиг. Дээр нь олон хүн надад тусалж дэмжиж байна. Энэ мэт энгийн амьдралын бүх зүйлст талархаж амьдрах нь үнэндээ хамгийн том аз жаргал буй за.

Хүний амь насыг хүртэж, орчлонгийн олон зүйлийн тус дэмээр өнөөдөр бид амьдарч байна. Үүнд талархаж, амьдрах эрч хүч дүүрэн бодисатвагийн зам мөрөөр алхах нь Шагжамүни бурхны туйлын хүсэл гэдгийг 89 нас хүрээд одоо дахин сэтгэлийн гүнээс ойлгож ухаарч байна.

Үүнийг гишүүд та бүхэн ч гэсэн сэтгэлийнхээ гүнээс ойлгох юм бол амьдрал тань жинхэнэ утга учиртай болно гэдэгт итгэлтэй байна.

Манай байгууллага 2 жилийн дараа 90 жилийн ой, 12 жилийн дараа 2038 онд 100 жилийн ойтойгоо золгох гэж байна.

Сүсэг бишрэл бүхий амьдралаар дамжуулж өрх гэрээ товхинуулж, хүүхэд залуусыг хүнлэг хүн болгон өгсөн хүмүүжүүлэх, улс орныхоо өв уламжлалыг залгамжлан энх тайван улсыг бүтээн байгуулах үйлийг бодитоор хэрэгжүүлэн урагш алхацгаая.

(Косей сонин, 2026 оны 1-р сарын дугаар)

